Ярилцлага өгөгчийн нэр	Шарав	Дугаар	L354
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэдалай сум
Төрсөн газар	Эрдэнэдалай сум	Төрсөн он	1915
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан суух байсан сүм хийд	Сангийн далай хийд	Сүм хийдийн дугаар	ДУЭД 001
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Жужа

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Сангийн далай хийд

Жужа: Та багадаа хаана амьдарч байсан бэ?

Шарав: Энд энэ хавийн нутагт амьдарч байсан.

Жужа: Та энэ Сангийн далай хийдийн тухай мэддэг юмаа ярих уу?

Шарав: Аа гурван дуган, дөрвөн дуган байсан.Энэ их дуганаас хойш бүрүүн зүүн хоёр дуган байсан. Өвгөн дуган гэж зүүн хойно байсан. Ингээд лав дөрвөн дуган байсан. За лам нар болвол ер нь нэлээн лам нар байсан даа.

Жужа: Ойролцоогоор хэдэн зуун лам байсан бол?

Шарав: Аа нэг тавиад лам байгаа биз дээ. Тэрнийг сайн тодорхой мэдэхгүй байна. Зуу ч хүрээгүй байх. Банди нартайгаа бол зуугаад лам нар байсан байх. Том лам нарыг нь яривал нэг тавиад лам байсан байх гэж санаж байна.

Жужа: Гадууpаа хэрэм хүрээтэй байсан уу?

Шарав: Аа тэр дуганы урагш энэ хашаанаас арай том хэрэм хашаа, хайс байсан. Дугандаа хэрэм байгаагүй ээ.Хайлан жас гэж харин цөөн лам нарын шавар хэрэмтэй жас байсан байх. Цогчин жас гэж хойно нь байсан байх.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

Жужа: Өөр жас байсан уу?

Шарав: Тэр бүрүүн үрдаа бас нэг жас энэ тэр гэж байсан. Тэрийг би сайн мэдэхгүй юм даа.

Энхбаяр: Тэр бүрүүн зүүн аймаг гэж байсан уу?

Шарав: Байсан юм гэнэ лээ. Чухам хаахнаа байсныг нь сайн мэдэхгүй байна.

Жужа: Энд суварга байсан уу?

Шарав: Суварга байсан. Энэ зүүн хойно л олон суварга байсан. Энд болвол харин нэг их олон суварга байсан уу, үгүй юу дуганы хажууд олон суварга байгаагүй байх. Зүүн хойд дэнжид олон суварга байсан.

Жужа: Энэ хийдийн алдартай лам нар ямар ямар лам байсан бэ?

Шарав: Базарын Ловон гэж хүн байсан. Шовго гавж гэж нэг том лам байсан. Той лам гэж бас нэг том байсан. Балдандамир гэж нэг том лам байсан.

Жужа: Энэ хойд овоог хэзээ тахиж байсан бол?

Шарав: Дандаа хавар ногооноор л тахидаг байсан. Зуны эхэн сар хавьд л.

Жужа: За баярлалаа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон